

Шерлок ба массив

Ватсон Шерлокт массив өгч, тухайн массивын ямар нэг элементийн хувьд түүний баруун талд орших элементүүдийн нийлбэр нь, түүний зүүн талд орших элементүүдийн нийлбэртэй тэнцүү байх тийм элемент байгаа эсэхийг тодорхойлж өгөхийг хүсчээ.

Жишээлбэл

$arr = [5, 6, 8, 11]$ гэсэн массивын хувьд 8 гэсэн утгатай элементийг сонгож авахад түүний зүүн гар талын элементүүдийн нийлбэр нь $5 + 6 = 11$, мөн баруун гар талд орших элементүүдийн нийлбэр нь 11 тул энэ массивт

бодлогын нөхцөлийг хангах элемент оршин байна гэдэг нь харагдаж байна.

Массивын эхний болон төгсгөлийн элементийн хувьд харгалзан түүний зүүн болон баруун талын элементүүдийн

нийлбэрийг 0 байна гэж үзнэ.

Тэгвэл өгөгдсөн массивт тухайн нөхцөлийг хангах ямар нэгэн элемент олдож байвал YES, бусад тохиолдолд

NO гэсэн үгийг хэвлэнэ үү.

Оролтын хэлбэр:

Эхний мөрөнд тестийн тоо T өгөгдөнө. Тест бүр нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Массивын элементүүдийн тоо n
- Массивын элементүүд болох n ширхэг тоонууд зайгаар тусгаарлагдан тус тус өгөгдөнө.

Хязгаарлалт:

- $1 \leq T \leq 10$
- $1 \leq n \leq 10^5$
- $1 \leq arr[i] \leq 2 \cdot 10^4$
- $0 \leq l \leq n$

Гаралтын хэлбэр:

Тест бүрийн хувьд тухайн массивд түүний баруун талын элементүүдийн нийлбэр нь зүүн талд орших

элементүүдийнхээ нийлбэртэй тэнцүү байх элемент олдож байвал YES, бусад тохиолдолд NO тус тус нэг мөрөнд хэвлэнэ.

Жишээ оролт 0:

2

3

1 2 3

4

1 2 3 3

Жишээ гаралт 0:

NO

YES

Тайлбар 0:

Эхний тестийн хувьд тийм алга байна..

Дараагийн тестний хувьд 2-р элементийн хувьд $a[0]+a[1]=a[3]$ буюу тийм элемент оршин байна.

Жишээ оролт 1

3

5

1 1 4 1 1

4

2 0 0 0

4

0 0 2 0

Жишээ гаралт 1

YES

YES

YES

Тайлбар 1

Эхний тестийн хувьд, $a[2]=4$ гэсэн элементийн хувьд нөхцөл биелж байна.

Хоёрдугаар тестийн хувьд, $a[0]=2$ буюу эхний элементийн хувьд нөхцөл биелж байна .

Гуравдугаар тестийн хувьд, $a[2]=2$ гэсэн элементийн хувьд нөхцөл биелж байна.

Орчуулсан : Хөвсгөл аймгийн Ирээдүй сургуулийн багш Д.Батмөнх